



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/15

Чойр


Аймгийн "Алдарт уяач" цол, тэмдэг
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 10 дугаар зүйлийн 10.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, Аймгийн Засаг даргын 2022 оны А/16 дугаар захирамжаар батлагдсан "Аймгийн Засаг даргын шагналын журам"-ын 3.1.3, 4.9, 5.1.1, 5.3, 5.5, 5.6, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уяж, сойсон хурдан хүлэг морьд нь улс, аймаг, бүсийн наадамд түрүүлж, айрагдаж, аймгийн "Алдарт уяач" цолны болзол хангасан Сүмбэр сумын Сансар багийн малчин Доржийн Баттөгс, Сүмбэр сумын Уулзвар багийн малчин Санжаагийн Баттөр, Сүмбэр сумын Найрамдал багийн малчин Доонямын Батсуурь нарт аймгийн "Алдарт уяач" цол, тэмдэг олгож, төсвийг хавсралтаар баталсугай.

2. Шагналын зардалд зарцуулагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400123


•
•

•

•

•

Аймгийн Засаг даргын 2024 оны
01 дүгээр сарын 30 ны өдрийн
1/45 дугаар захирамжийн
хавсралт



АЙМГИЙН АЛДАРТ УЯАЧИД ОЛГОХ ШАГНАЛЫН
ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо/хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Календарь	ш	3	4,500	13,500
2	Торго	м	3	50,000	150,000
3	Бэлэгний уут	ш	3	3,500	10,500
4	Чацаргана	кг	3	18,000	54,000
5	Сүү	л	3	6,000	18,000
6	Хадаг	ш	3	8,000	24,000
7	Боржигин морин хуур	ш	3	850,000	2,550,000
8	Өргөмжлөл	ш	3	60,000	180,000
НИЙТ ҮНЭ				1,000,000	3,000,000

1

.

.

-

.

.

.

100